

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсон.

Байгууллагын нэр:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК

Нэгжийн нэр:

Дамжуулах сүлжээ ашиглалтын газар
Дамжуулах сүлжээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Удирдах албан тушаалтан

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Дамжуулах сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулах.	
Албан тушаалын зорилт:	
1. Хэлтсийг удирдлагаар хангах, газрыг төлөөлөх; 2. Газрын чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; 3. Удирдлагыг мэдээллээр хангах, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.	
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Харьяа нэгжүүдийг удирдах, үүрэг, даалгавар өгөх, хяналт тавих, ажлыг нь дүгнэх; 2. Чиг үүрэгт хамаарах асуудлыг санал оруулж, шийдвэрлүүлэх; 3. Чиг үүрэгт хамаарах асуудлаар компанийн газар, нэгжүүдтэй харилцах.
2 дугаар зорилтын хүрээнд	1. Үндсэн сүлжээний сүлжээний тасралтгүй, найдвартай, тогтвортой ажиллагаанд хяналт тавьж, техникийн бэлэн байдлыг хангах, сүлжээ ашиглалтын үйл ажиллагааг технологийн удирдлагаар хангах, хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх удирдан зохион байгуулах; 2. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, сүлжээг өргөтгөх, өөрчлөлт, шинэчлэлт хийх, боловсронгуй болгох, шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулж, шийдвэрлүүлэх; 3. Хэлтсийн чиг үүрэгт заасан бусад үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
3 дугаар зорилтын хүрээнд	1. Удирдлагыг салбарын чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд мэдээллээр хангах; 2. Удирдлагад ажлаа тайлагнах, танилцуулах; 3. Удирдлагаас чиг үүргийн хүрээнд өгөгдсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх.

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд, инженер /061/;
Мэргэшил	Мэргэшил шаардахгүй. Мэргэшсэн бол давуу тал болно.
Туршлага	Мэргэжлээрээ 10-с дээш, Харилцаа холбооны салбарт 5-аас дээш, Техник ашиглалтын чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх.
Ур чадвар	Техник, технологийн ашиглалт, үйлчилгээнд гардан ажиллах чадвартай, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, гадаад хэлний зохих мэдлэгтэй, хэрэглээний программ дээр ажиллах чадвартай.
Ажлын байрны болон орон нутгийн онцлог, цаг үеийн нөхцөл байдал, хүний нөөцийн хэрэгцээг үндэслэн энэхүү тусгай шаардлагын "Туршлага" хэсэгт заасныг тухайн тохиолдолд өөрчлөн тогтоож болно.	

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Газрын дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Инженер техникийн ажилтнууд Нийт: 41	Бусад харилцах субъект: 1. Компанийн нийт ажилтнууд 2. Холбогдох бусад байгууллага, иргэн хуулийн этгээд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

БОЛОВСРУУЛСАН:	БАТАЛСАН:
<p>ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p></p> <p>Д.МЯНГАНБААТАР</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>	<p>МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p></p> <p>Б.МӨНХБАТ</p> <p>2023 оны 03-р сарын 17-ны өдөр</p>